МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

/Эрх зүйн орчин түүний хэрэгжилт, цаашдын чиг хандлага/

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
Д.ШИЖИР-ЭРДЭНЭ

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

1970-аад оны сүүл, 1980-аад оны эхээр АНУ-ын хувийн хэвшлийн үйлдвэрүүд анх ашиглаж эхэлсэн.

Үүний дараагаас Европын холбоо, Австрали зэрэг улсуудад нэвтрүүлсэн.

Австрали, АНУ, Европын холбоо зэрэг хөгжилтэй орнууд болон Уганда зэрэг хөгжиж буй орнууд үндэсний хууль тогтоомжоо баталж гаргасан байна.

МОНГОЛ УЛСАД

- Манай улс Байгаль орчны аудитын зохицуулалтыг “Байгаль орчныг хамгаалах тухай” хуульд бие даасан тусгай бүлэг оруулж, 2012 оны 5 дугаар сард УИХ-аар батлуулсан.

- “Байгаль орчны аудит” гэж байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг **хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг** хэлнэ гэж заасан байдаг.

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН


- **Байгаль орчныг хамгаалах тухай хууль /2012 он/;**
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-126 дугаар тушаалаар батлагдсан “**Байгаль орчны аудит хийх эрх олгох журам, аргачлал”;**
- “**Байгаль орчны аудит хийх эрх олгох журам, ерөнхий аргачлал”** Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн А-809 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан;
- **“Байгаль орчны аудитын мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн”-ийг БОАЖ-ын Сайдын 2020 оны 11-р сарын 04-ны өдрийн А/632-р тушаалаар шинээр баталсан.**

БОА-ЫН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Байгаль орчны аудит нь:

- Тухайн байгууллагын байгаль орчинд учруулж болох аливаа сөрөг нөлөө, хохирол, үр дагаврыг арилгах арга хэмжээ авах;
- Үйлдвэр, ААНБ-ын экологи-эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх;
- Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйлдвэрлэл явуулахад төсөл хэрэгжүүлэгчид туслах;
- Учирч болох алдагдал, хохирлоос урьдчилан сэргийлэхэд чиглэдэг.

МОНГОЛ УЛСАД БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫГ НЭВТРҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ



АУДИТЫН АЧ ХОЛБОГДОЛ

01 БО хамгаалах

02 Эрх зүй


Улсын хууль дүрэм, ОУ-д нэгдэн орсон гэрээ конвенцийг даган мөрдөж

03 Асуудлаас урьдчилан сэргийлэх

Одоогийн болон ирээдүйд учирч болох асуудлуудыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх

04 БО-ны сайн гүйцэтгэл

Компаниуд байгаль орчны сайн гүйцэтгэлд суурилж ажиллах



05 Зардал хэмнэх

Зардал хэмнэх боломжуудыг олж илрүүлэх, жишээ нь хог хаягдлын үр ашигтай менежмент

06 Мэдээлэл

Өөр бусад ААН үйлдвэрүүд болон өөрийн охин компаниудтай мэдээлэл солилцох, харьцуулалт хийх боломжыг олгоно

07 Амлалт

Бизнес нь байгаль орчин хамгаалах талаар төр, олон нийт, ажилчид болон бусад оролцогч нарт амалсан амлалтаа бичлүүлэх

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ЭРХ ЗҮЙН ШААРДЛАГА

БОХ тухай хууль:

Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь **хоёр жил тутам хийлгэж,** холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ.

БОННҮ-ний журам:

Байгалийн нөөц ашиглан үйл ажиллагаа явуулж буй төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд ***нэмэлт тодотгол*** хийлгэхдээ тухайн төсөлд хийлгэсэн байгаль орчны төлөвлөгөөт аудитын зөвлөмж, тайланг ирүүлнэ.

БОМТ-ний журам:

Тухай жилийн БОМТ-г батлуулахад аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлэхээр зохицуулсан.

МХЕГ-ын хяналтын хуудаст:

Төсөл хэрэгжүүлэгчийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах баримт бичгийн жагсаалтад туссан.

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН АНГИЛАЛ

Байгаль орчны аудитыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус гэж хоёр ангилдаг.

- **Байгаль орчны төлөвлөгөөт аудитын жагсаалт.**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн А-809 дүгээр тушаалын 3 дахь хэсэгт аймаг, нийслэлийн БОАЖГ нь тухай жилийн тайлан болон дараа жилд төлөвлөгөөт/хуваарьт аудит хийлгэх байгууллагын жагсаалтыг 12-р сарын 01-ны дотор яаманд ирүүлэхээр зохицуулсан.

- **Байгаль орчны төлөвлөгөөт бус аудитын жагсаалт.**


Төсөл хэрэгжүүлэх сум, дүүргийн Засаг дарга болон Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиалан хийлгүүлнэ.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫН ТӨВ БАЙГУУЛЛАГААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

- Байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагаас хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн.
- Боловсон хүчнийг бэлтгэсэн. **/4 сургалт, 164 аудитор/**
- Аудитын мэргэжлийн байгуулагын эрх олгосон. **/34 ААНБ/**
- Аудитын тайланг аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас авч нэгтгэн сан бүрдүүлээд байна.
- Аудитыг Мэргэжлийн хяналтын газрын хяналтын хуудсанд оруулав.


БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙЛГЭСЭН БАЙДАЛ

/2018 оны байдлаар/



104

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТАД ХАМРАГДСАН ТӨСЛИЙН АНГИЛАЛААР



БОА-ЫН МЭДЭЭЛЛИЙН САН

www.eic.mn/audit/

Мэдээллийн ерөнхий агуулга:

Нэг. Эрх зүйн орчны талаарх мэдээлэл:


Хоёр. Байгаль орчны аудит хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагын талаарх мэдээлэл;


Гурав. Байгаль орчны аудиторуудын талаарх мэдээлэл;

Дөрөв. Байгаль орчны аудит хийлгэсэн байгууллагын талаарх мэдээлэл;

Тав. Бусад мэдээлэл;

БОА-ын мэдээллийн сан





Байгаль орчны аудитын мэдээллийн санг www.eic.mn/audit/ шинээр байгуулж, Байгаль орчны аудит эрх бүхий 34 байгууллага, эдгээр байгууллагын 2014-2019 оны хооронд гүйцэтгэсэн байгаль орчны аудитын тайлангийн талаарх жагсаалтыг мэдээллийн санд бүртгэв.

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ХЭРЭГЖИЛТИЙН МОНИТОРИНГ ХИЙХ АЖИЛД ХАМРАГДСАН ТӨСЛҮҮД

СЭЛЭНГЭ АЙМАГ:

- “Бороо Гоулд” ХХК-ийн алтны үндсэн орд ашиглах Бороогийн ил уурхай, баяжуулах үйлдвэр;
- “Тод ундарга” ХХК-ийн алтны шороон орд ашиглах Нэргүй Хөндий ил уурхай.
- “Болд Төмөр Ерөө Гол” ХХК-ийн төмрийн хүдэр ашиглах Баянголын уурхай,

ДОРНОД АЙМАГ:

- “Петро Чайна Дачин Тамсаг” ХХК-ийн газрын тосны Бүтгээдэхүүн хуваах гэрээт ХХІ талбай
- “Шинь Шинь” ХХК-ний Улааны холимог металын далд уурхай

СҮХБААТАР АЙМАГ:

- “Цайрт Минералс” ХХК-ийн “Төмөртийн-Овоо”-ны цайрын Уулын баяжуулах үйлдвэр
- “Хунт Өгөөж” ХХК-ийн жоншны уурхай


Ажлын хэсэг Сэлэнгэ аймагт





Ажлын хэсэг Дорнод, Сүхбаатар аймагт





БОА-ЫН МОНИТОРИНГИЙН ҮР ДҮНГЭЭС /БОДИТ БАЙДАЛ/

Сайн тал:

- Байгаль орчны аудитыг хуулийн хугацаанд тогтмол хийх үүрэг, аудитын ач холбогдлыг бүрэн ойлгосон-(2/7)
- БОА-ын зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж ажилладаг-(4/7)
- БОА-ын эрх бүхий ААН-ийн аудиторуудаасаа илүү чадавх, туршлагатай-(2/7)
- БОА хийлгэснээр тухайн уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн үйл ажиллагаад дэвшил гарсан-(2/7)

Сул тал:

- БОА-ыг захиалан гүйцэтгүүлэх байгууллагыг сонгох, Ажлын даалгавар боловсруулах чадавх сул-(7/7)
- БОА-ын зөвлөмжийн дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг аймгийн БОАЖГ-т хүргүүлээгүй-(6/7)
- БОА-ын тайлангийн нууцлалын талаар тодоррхой ойлголт дутмаг-(7/7)
- Хуулийн дагуу БОА-ыг захиалан гүйцэтгүүлсэн хэдий ч тайлан, дүгнэлт, зөвлөмжийг ашиглаагүй, ач холбогдлыг бүрэн ойлгоогүй-(5/7)

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ХҮРЭЭНД НИЙТЛЭГ ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖ

1. **Дотоод хяналт** шалгалтыг тогтмолжуулж, түүний мөрөөр зохих ажлын үр дүнг сайжруулах;
2. **Хөдөлмөр аюулгүй** ажиллагааг хангахад тавих хяналт сайжруулах;
3. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа **усны найрлагад** тусгай шинжилгээ жил бүр хийх;
4. Техникийн нөхөн сэргээлт хийсэн тайлбайд хийж буй **биологийн нөхөн сэргээлтийн чанарыг сайжруулах**;
5. **Шимт өнгөн хөрсийг хадгалах**, зохих хугцааны дараагаар техникийн нөхөн сэргээлт хийгдсэн үед биологийн нөхөн сэргээлтэд ашигладаг **технологийг өөрчлөх;**
6. **Химийн бодис**ын тавиур нь гулсаж унахаас хамгаалсан хаалт, саадтай байх. **Эрсдлийн үнэлгээ**ний тэмдэглэгээ тавих.
7. Хууль, тогтоомжид заасан дагуу орон нутгийн засаг захиргааны байгууллагад **тайлан, мэдээг хугацаанд** нь албан ёсоор хүргүүлэх;

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

- Аудит хийлгэсэн тоо баримтаас үзэхэд аж ахуйн нэгж, байгууллага хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахгүй байна.
- Компаниудаас асуумж авахад аудитын мэргэжлийн боловсон хүчний чадавхи сул гэсэн байна.
- Аудитын эрх бүхийн аж ахуй нэгжүүдэд хариуцлагын тогтолцоог илүү сайжруулах шаардлагатай.
- Аж ахуй нэгж, байгууллагууд БОА-ын зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд тайлагнадаггүй.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Шинэчлэн батлагдсан Байгаль орчны аудитын эрх зүйн актын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;
- Байгаль орчны аудитын Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааги эхлүүлж, жигдрүүлэх;
- Байгаль орчны аудитын Мэргэжлийн байгууллагуудад зориулсан сургалт хийх;
- Байгаль орчны аудитор бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж, БОА-ыг шинээр бэлтгэх;
- Байгаль орчны аудитын мэдээллийн санг баяжуулж, хэрэглээг нэмэгдүүлэх;
- Төсөл хэрэгжүүлэгч нарт зориулсан сургалт, шаардлага





АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ШИНЭЧЛЭН БАТЛАГДСАН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙХ ЭРХ ОЛГОХ ЖУРМЫН ТАНИЛЦУУЛГА

БОАЖ-ын Сайдын 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн А/809 дүгээр тушаалаар батлагдсан.
ЗХХА-ын 4561-т бүргүүлэв.

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙХ ЭРХ ОЛГОХ ЖУРАМ

(өмнөх жураматай харьцуулсан байдал)

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй журмын зохицуулж буй харилцаа

- Байгаль орчны ауиторын сургалтыг БОАЖЯ захиалах, МУИС гүйцэтгэх;
- Сургалтанд хамрагдаж шууд байгаль орчны аудиторын хугацаагүй эрх авах;
- Аудиторыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоо байхгүй;
- Аудиторын ур чадвар, туршлагыг үнэлэх тогтолцоо байхгүй;
- Нэгдсэн дагаж мөрдөх ёс зүйн дүрэм байхгүй;
- Аудитын чанарын баталгаажуулалт байхгүй;
- Байгаль орчны аудиторыг сонгон шалгаруулахгүйгээр зөвхөн сургалтын хичээлээр шалгалт өгч эрх олгож байна.

Шинэ журмын төслөөр бий болж буй зохицуулалт

- Байгаль орчны аудитын орон тооны бус мэргэжлийн зөвлөлтэй байх **/Тусгай журмаар зохицуулах/;**
- Аудитын сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах, сургалтын хөтөлбөрийг хянан баталгаажуулах;
- Аудиторын эрхийг шалгаруулалтаар эрх олгох;
- Аудиторын эрх хугацаатай, сунгахад шалгууртай, байх;
- Аудитын байгууллагын эрх олгох, сунгахад шалгууртай байх;
- Аудитын болон аудиторын эрхийг цуцлах тогтолцоог бүрдүүлсэн; /хариуцлагжуулах/
- Нийтээр дагаж мөрдөх байгаль орчны аудиторын ёс зүйн зарчимтай байхаар журамд тусгасан.

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙХ ЭРХ ОЛГОХ ЖУРАМ

(Өмнөх журааматай харьцуулсан байдал)

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журам:

4 зүйл, 24 заалт


- Нийтлэг үндэслэл
- Аудит хийх хуулийн этгэдэд тавигдах шаардлага
- Эрх олгох, сунгах түдгэлзүүлэх
- Бусад

Шинэчилсэн найруулга:

11 зүйл, 40 заалт

- Нийтлэг үндэслэл
- Байгаль орчны аудит хийх эрх олгох, сунгах, цуцлах
- Байгаль орчны аудиторын эрх олгох, сунгах, цуцлах
- Байгаль орчны аудит хийх хуулийн этгээдийн эрх, үүрэг
- Байгаль орчны аудитын захиалагчийн эрх, үүрэг
- БОА-ын ажил гүйцэтгэх болон Экологийн хариуцлагын гэрээ, даатгал
- Байгаль орчны аудиторын ёс зүйн зарчим, зөрчил
- Байгаль орчны аудитын чанарын баталгаажуулалт
- БО-ны салбарын ТББ, олон нийтийн оролцоо
- БО-ны аудитор, аудит хийх хуулийн этгээдтэй холбоотой гомдол, маргаан шийдвэрлэх
- Бусад

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ЕРӨНХИЙ ПРОЦЕСС



- Байгаль орчны аудитын орон тооны бус мэргэжлийн зөвлөл
- БОАЖ+Байгаль орчны аудитын сургалт явуулахаар эрх авсан байгууллага

- БОАЖЯ
- Байгаль орчны аудитын орон тооны бус мэргэжлийн зөвлөл

- БОАЖЯ-ны шийдвэр
- Байгаль орчны аудитын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт

- БОАЖЯ
- Байгаль орчны аудитын орон тооны бус мэргэжлийн зөвлөл

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙХ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА

(байгаль орчны аудитын эрх авах процесс)

Байгаль орчны аудитын баг бүрдүүлэх

- Аудитын багийн гишүүд байгаль орчны аудитын сургалтанд хамрагдсан байх
- Байгаль орчны аудиторын эрх авсан 4-өөс доошгүй аудитортой байх
- Аудиторууд нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх

Байгаль орчны аудитын эрх авах сонгон шалгаруулалт

- Байгаль орчны аудитын багийн гишүүд ёс зүйн зөрчилгүй байх
- Мэдлэг, ур чадварын шаардлага хангасан байх
- Байгаль орчны аудитын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гаргуулсан байх

Байгаль орчны аудитын эрх сунгах

- 3-н жилийн хугацаатай эрхийн гэрчилгээ
- Аудитын багийн гишүүд ёс зүйн зөрчилгүй байх
- Аудитын чанарын хянан магадлагаа хийлгэсэн байх
- Сайн дурын аудит хийсэн байх гэх мэт
- Эрх сунгах
- Эрх цуцлах

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТОР

(Байгаль орчны аудиторын эрх авах процесс)

Байгаль орчны аудитын сургалтад хамрагдах

- Байгалийн шинжлэх ухаан, хүрээлэн буй орчин түүнтэй холбогдох инженерчлэлийн болон эрх зүйн мэргэжилтэй байх
- Байгаль орчны чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байх

Байгаль орчны аудиторын сонгон шалгаруулалтад хамрагдах

- Байгаль орчны аудитын сургалтанд хамрагдсан байх
- Мэдлэг, ур чадварын шаардлага хангасан байх

Байгаль орчны аудиторын эрх авах, сунгах

- Сонгон шалгаруултад тэнцсэн байх
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдах
- 5-н жилийн хугацаатай эрх, энэ хугацаанд 6-аас доошгүй багц цаг цуглуулах (гадаад, дотоод сургалт, сайн дурын аудит гэх мэт)
- Ес зүйн зөрчилгүй байх

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ

(Захиалагч, гэрээлэгч аудит хийлгэх процесс)

БОХТ хуулийн дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх

- Байгаль орчны аудит хийх эрх бүхий аудитын байгууллагыг сонгох, гэрээ хийх;
- Аудит хийх нөхцөл боломжоор бүрэн хангах
- Байгаль орчны аудитын үйл ажиллагаанд саад учруулахгүй байх, хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх

Байгаль орчны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх

- Байгаль орчны аудитын зөвлөмжид санал оруулах
- Байгаль орчны аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
- Аудитын зөвлөмжийн дагуу байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөлийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх

Байгаль орчны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнах, санал гомдол

- Байгаль орчны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуух хариу арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг аймгийн БОА-нд хүргүүлэх
- Байгаль орчны аудитын байгууллага, аудитортой холбогдох ноцтой асуудлын талаарх гомдол саналыг БОАЖЯ-нд гаргах

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙГДЭХ ПРОЦЕСС



ЖУРМЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

БОАЖЯ-ны ТНБД-ын 2018 оны 04-р сарын 19-ны өдрийн А/146 дугаар тушаалаар байгуулагдсан 11 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг ажилласан .

Ажлын хэсэгт:

- **БОАЖЯ-наас:** БОҮАХ-ийн дарга А.Энхбат, ахлах мэргэжилтэн Д.Шижир-Эрдэнэ, мэргэжилтэн Б.Батбаяр, ХШҮДАГ-ын мэргэжилтэн Х.Оюунбилэг, ХХ-ийн мэргэжилтэн О.Батсайхан;
- **УУХҮЯ-наас:** ХШҮДАГ-ын дарга Г.Ганхүү;
- **Төрийн бус байгууллагаас:** “Байгаль орчны аудитын холбоо”-ны УЗ-ын дарга Б.Энхбаяр, гүйцэтгэх захирал О.Алтансүх;
- **СЕСМИМ төслөөс:** Төслийн ахлах зөвлөх Г.Сурахбаяр, хуулийн зөвлөх Б.Лхамсүрэн, зөвлөх Ш.Анармаа, мэргэжилтэн Д.Өлзийбаяр





АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.